



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Аймагын нийгэм,
эдийн засгийн
байдал
2017/12

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2017/12



Dundgovi@nso.mn

www.1212.mn



Monstat



ezStat

Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг МОНСТАТ, ezStat аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad Төхөөрөмжтэй бол App store-с андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татаж авч, суулгаж ашиглах боломжтой.

12 - р сар

- Сумдын товч мэдээлэл
- Хамгийн өндөр, хамгийн бага үзүүлэлттэй сумд
- Төсвийн орлого, /сумаар/
- Төсвийн зарлага
- Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
- Суурин хүн амын тоо, шилжих хөдөлгөөн
- Хүн ам нийгмийн зарим үзүүлэлт
- Хүн амын төрөлт, нас баралт
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үзүүлэлт
- Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
- НД –ын сангийн орлого, зарлага, даатгуулагчийн тоо
- НД-ын шимтгэл, тэтгэвэрийн хэмжээ
- Боловсрол
- Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- Халдварт өвчин
- Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт
- Мал тооллого
- Төл бойжилт, том малын зүй бус хорогдол
- Тариалсан талбайн мэдээ
- Аж үйлдвэр
- Барилга
- Тээвэр холбоо
- ХАА бүтээгдэхүүний үнэ
- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн мэдээ
- Хэрэглээний үнийн индекс
- Газар
- Гэмт хэрэг /сумдаар/
- Цаг уур

Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2017 оны жилийн эцсийн байдлаар)



I.Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2017 оны жилийн эцэст орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 105.6 хувьтай буюу 7373.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 92.4 хувьтай буюу 2449.7 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 9910.1 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 102.3 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 39239.6 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 100.7 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 6292.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 23639.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 1648.8 сая төгрөг нийт 31779.2 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Дэрэн, Говь-Угтаал, Өлзийт, Гурвансайхан, Баянжаргалан, Дэлгэрцогт сумд 4.5-36.0 хувиар буюу 4870.8-112567.4 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө тасласан бол бусад бүх сумд төлөвлөгөөгөө 3.8-17.7 хувиар давуулан биелүүлсэн байна.



II.Төсвийн зарлага

2017 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 39968.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 18418.0 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өсч, нийт зардлын 46.1 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 2.2

хувиар өсч 2036.7 сая төгрөг болсон байна. Мөн байр ашиглалттай холбоотой бусад зардал өмнөх оноос 2.1 хувиар өсч 3298.2 сая төгрөг, хангамжийн бараа материалын зардал 807.6 сая төгрөг болж өмнөх оноос 14.2 хувиар, норматив зардал 1435.4 сая төгрөг болж 3.1 хувиар, эд хогшил урсгал засварын зардал 673.4 сая төгрөг болж 2.4 дахин, томилолтын зардал 170.4 сая төгрөг болж 15.1 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 2644.3 сая төгрөг болж 29.3 хувиар, бусад урсгал шилжүүлэг 6317.5 сая төгрөг болж 31.0 хувиар тус тус өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хамгийн их буурсан зардал хөрөнгийн зардал 44.2 хувиар буурч 3110 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 852.4 сая төгрөг болж 5.5 хувиар, Засгийн газрын дотоод шилжүүлэг 205.0 сая төгрөг болж 0.3 хувиар тус тус буурсан байна.



III. Банк


Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өсч 95817.6 сая төгрөг болов. Үүнээс анхаарал хандуулах зээл 381.7 сая төгрөг, чанаргүй зээл 602.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 2.4 хувиар өсч, чанаргүй зээл 2.8 хувиар буурсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өсч 40317.2 сая төгрөг болов.



IV. Хүн амын зарим үзүүлэлтүүд

Хүн ам: 2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн ам 46383 болж өмнөх оноос 686 хүнээр буюу 1,9 хувиар өслөө. Өндөршил, Өлзийт сумдын хүн ам 1,42-1,7 хувиар буурсан бол бусад бүх сумдад өссөн байна. Нийт хүн амын өсөлтийг сүүлийн 6 жилээр авч үзвэл 2012-2014 онуудад хүн амын тоо 0,4-0,5 хувиар буурч байсан бол 2014-2017 онуудад 1,3-1,8 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Нийт хүн амын 49,8 хувь буюу 23078 нь эмэгтэй 50,2 хувь буюу 23305 нь эрэгтэйчүүд байна

Хүн амын тоо 2012-2017 оны байдлаар



Аймгийн хэмжээнд 100 болон түүнээс дээш настай 1 хүн байгаа нь Сайхан-Овоо сумын 4-р багт амьдарч байна. Нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 0-16 насны 15018 хүн байгаа нь нийт хүн амын 32,3 хувь, 16-59 насны 27604 хүн байгаа нь 59,5 хувь, 60 болон түүнээс дээш насны 3761 хүн байгаа нь нийт хүн амын 8,1 хувийг бүрдүүлж байна.

Өрх: Өрхийн тоо 14556 болж өмнөх оноос 428 өрхөөр буюу 3,0 хувиар өслөө. Өрхийн тоо өссөнөөр нэг өрхөд ногдох хүн амын тоо буурч 3,2 болжээ.

Хөдөөд 7333 өрхийн 23341 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 50,3 % юм. Аймгийн төвд 3732 өрхийн 12339 хүн байгаа нь нийт хүн амын 26,6% , сумын төвд 3491 өрхийн 10703 хүн амьдарч байгаа нь 23,1 хувь байна.


Нийт өрхийн тоо 2012-2016



Нийт өрхийн 73.6 хувь буюу 10727 нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 26.4 хувь буюу 3829 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна




Аймгийн хэмжээний нийт өрхийн 21,9 хувь нь 1 ам бүлтэй, 19,9 хувь нь 4 ам бүлтэй, 17,7 хувь нь 3 ам бүлтэй, 17,4 хувь нь 2 ам бүлтэй, 13,6 хувь нь 5 ам бүлтэй бол 9,5 хувь нь 6 болон түүнээс дээш ам бүлтэй өрх байна. Аймгийн хэмжээнд 18 хүртлэх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 451 байна.



Ганц бие ахмад настай өрхийн тоо 1029 байгаагийн 273 нь буюу 26,5 хувь нь 60-аас дээш настай эрэгтэй, 756 нь буюу 73,5 хувь нь 55 –аас дээш настай эмэгтэй байна

Төрөлт: 2017 онд нийт 1022 хүүхэд шинээр мэндэлсэн нь өнгөрсөн оноос 85 хүүхдээр буюу 7,7 хувиар буурсан байна. Шинээр төрсөн хүүхдийн 546 нь буюу 53,4 хувь нь эрэгтэй хүүхэд, 476 нь буюу 46,6 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Аймгийн хэмжээнд 1000 хүнд ногдох төрөлт 22,0 болж 2,3 пунктээр буурсан байна.



Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Гурвансайхан сумдад төрөлт өмнөх оноос нэмэгдсэн бол бусад сумдад 2,5-14,6 хувиар буурсан байна

Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт: Энэ онд 255 гэрлэлт бүртгэгдсэн нь өмнөх оноос 86 гэрлэлт буюу 50,8 хувиар өссөн байна. Сайнцагаан суманд 99, Адаацаг суманд 31, Луус суманд 19, Эрдэнэдалай суманд 18 гэрлэлт бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Энэ онд 30 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 6,2 хувь буюу 2 тохиолдолоор буурчээ. 2017 оны байдлаар нийт 16 хүүхэд үрчлэгдсэн нь өнгөрсөн оноос 5 тохиолдолоор буурсан байна.

Нас баралт: 2017 онд аймгийн хэмжээнд 248 хүн нас барсан нь өмнөх оноос 66 хүн буюу 21,0 хувиар буурсан байна. Нас баралтын 62,5 хувийг эрэгтэйчүүд, 37,5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Сумдаар авч үзвэл Гурвансайхан, Сайхан-Овоо сумдад нас баралт 2-3 хүнээр өссөн бол бусад 13 суманд буурсан байна.

Аймгийн хэмжээнд 1000 хүнд ногдох нас баралт 5.3 болж өмнөх оноос 1.6 пунктээр буурсан байна.

Шилжилт хөдөлгөөн: Хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээгээр 2017 онд тус аймагт 777 хүн шилжин ирж өмнөх оноос

76 хүнээр буюу 10,8 хувиар өссөн байна. Шилжин ирсэн нийт хүн амын 70,9 хувь буюу 511 нь насанд хүрэгчид, 266 нь буюу 29,1 хувь нь 16-аас доош насны хүүхэд байна. Шилжин явсан хүн амын тоо 609 болж өмнөх оноос 546 хүнээр буюу 52,7 хувиар буурсан байна. Шилжин явсан нийт хүн амын 434 нь буюу 71,3 хувь нь насанд хүрэгчид байгаа бол 28,7 хувь нь буюу 175 нь 0-16 насны хүүхэд байна. Аймаг доторх шилжих хөдөлгөөн 2926 бүртгэгдсэн нь өмнөх оноос 10,6 хувиар өссөн байна.

Өнчин хүүхэд: Аймгийн хэмжээнд 32 бүтэн өнчин хүүхэд байгаагийн 13 нь эмэгтэй. 30 нь 5 дээш насны хүүхэд байгаа бол 0-4 насны 2 хүүхэд байна. Хагас өнчин 390 хүүхэд байгаагийн 205 нь эмэгтэй хүүхэд байна. Хагас өнчин хүүхдүүдийн 260 буюу 66.7 хувь нь 10-с дээш насны хүүхэд, 94 нь 5-9 насны хүүхэд, 36 нь 0-4 насны хүүхэд байна.




Өрх толгойлсон эцэг эх: 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүний тоо 1136 болж өмнөх оны мөн үеэс 9,1 хувиар өссөн бол эдгээрийн 89,9 хувь нь эмэгтэйчүүд 10,1 хувь нь эрэгтэйчүүд байна. Нийт өрх толгойлсон хүмүүсийн 819 нь 1-3 хүүхэдтэй, 245 нь 3-5 хүүхэдтэй, 72 нь 6 болон түүнээс дээш хүүхэдтэй байна.

Ганц бие өндөр настан: Ганц биеэр амьдарч байгаа ахмад настаны тоо 1029 болж өнгөрсөн оноос 40 -р буурчээ. Тэдгээрийн 756 нь 55-с дээш насны эмэгтэйчүүд 273 нь 60-с дээш насны эрэгтэйчүүд байна. Үүнээс Сайнцагаан суманд 312, Эрдэнэдалай суманд 142

ахмад настан ганцаараа амьдарч байгаа нь өндөр үзүүлэлт юм. Аймгийн хэмжээнд тэтгэвэр тэтгэмж тогтоолгоогүй 3 ахмад настан байгаагийн 2 нь Эрдэнэдалай сум, 1 нь Цагаандэлгэр сумын ахмад настан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн: 2017 оны эцсээр аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1830 хүн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4,7 хувиар өссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 43,0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл:

- Харааны бэрхшээлтэй 190. Үүнээс эмэгтэй 58
- Ярианы бэрхшээлтэй 61 . үүнээс эмэгтэй 25
- Сонсголын бэрхшээлтэй 122. Үүнээс эмэгтэй 56
- Хөдөлгөөний бэрхшээлтэй 404. Эмэгтэй 163
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй 428. Эмэгтэй 212
- Хавсарсан бэрхшээлтэй 104. Эмэгтэй 48

-Бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй 521 хүн, эмэгтэй 244 хүн байна. Төрлөөр нь авч үзвэл нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 47,6 хувь нь төрөлхийн, 39,9 хувь нь ердийн өвчнөөр, 2,5 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 10 хувь нь осол гэмтлээр хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс байна.



V.Бүртгэлтэй ажилгүйчүүд

2017 оны 12 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа 911 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 47.3 хувь буюу 431 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 303 ажилгүйчүүд ногдож байхад Говь-Угтаал 951, Баянжаргалан 377, Сайнцагаан 385, Луус /395/, Дэлгэрцогт суманд /401/, Өндөршил /495/ байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 18.0 хувь нь дипломын болон баклавын дээд, 4.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 8.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 36.0 хувь нь бүрэн дунд, 22.0 хувь нь суурь, 9.0 хувь нь бага, 3.0 хувь нь боловсролгүй иргэд байна.



VI.Ажлын байрны зуучлал


Хөдөлмөрийн хэлтсийн 2017 оны 12 сарын мэдээгээр нийт 509 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 218 хүнээр нэмэгдсэн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 23.4 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, 32.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 8.3 хувь нь барилга, 5.1 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, 5.3 хувь нь уул уурхай олборлолт, 4.5 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, 7.7 хувь нь боловсролын салбар, 2.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 2.8 хувь нь цахилгаан эрчим хүч, уур агааржуулалт, 2.6 хувь нь хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн чиглэлд зуучлагдсан бол үлдсэн хувь нь бусад салбарт зуучлагджээ.



VII.Боловсрол

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 8084 болж өнгөрсөн оноос 0.3 хувиар өссөн байна.

ЕБС-д суралцагсад



2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийг 714, 12-р ангийг 528 хүүхэд төгссөн байна. 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 811 хүүхэд элссэн нь өмнөх хичээлийн жилээс 0.9 хувиар буурсан байна.

Дотуур байранд суудаг хүүхдийн тоо энэ хичээлийн жилд өмнөх оноос 17.5 хувиар өсч 965 хүүхэд болжээ.



VIII. Нийгмийн даатгал

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны жилийн эцсийн байдлаар 28119,2 сая төгрөг, зарлага 27283,3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 1905,4 сая төгрөг буюу 7,3 хувь, зарлага 994,1 сая төгрөг буюу 3,8 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2017 оны жилийн эцэст 11072 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2430 хүн буюу 21.9 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4186 хүн буюу 37,8 хувь нь төсөвт байгууллагаас 4456 хүн буюу 40.2 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2017 оны жилийн эцсийн байдлаар 22275,2 сая төг болж, үүний 82.3 хувийг өндөр настны, 11,9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн,

2,9 хувийг тэжээгчээ алдсаны, 2.9 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6530 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 80.8 хувь буюу 5278 хүн өндөр насны, 13,9 хувь буюу 905 хүн тахир дутуугийн, 3.5 хувь буюу 230 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 117 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны эхний 12 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2401, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авагчид 50, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 224 хүн байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 39059 иргэн байгаагийн 72,1 хувь буюу 28143 төр хариуцах иргэд, 15.9 хувь буюу 6229 малчид, 9.8 хувь буюу 3827 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 2.2 хувь буюу 860 оюутан суралцагсад, ял эдэлж буй хоригдол байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 10895,1 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 2,1 хувиар буюу 223,8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө бүх сумд давуулан биелүүлсэн байна.



ҮI. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 878 эх төрсөн нь өнгөрсөн мөн үеэс 77 төрөлтөөр буурсан ба нийт 881 хүүхэд амьд төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 89,3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

2017 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн мөн үеэс 8 тохиолдлоор буурсан ба Нэгдсэн эмнэлэгт 3 нярай, Дэрэн суманд 1 нярай, Сайхан-Овоо суманд 1 нярай, Боржгин мандал өрхийн эмнэлэгт 1 хүүхэд амьсгалын замын өвчний улмаас, Дэлгэрхангай, Цагаандэлгэр суманд тус бүр нэг нэг хүүхэд ослын улмаас эндсэн байна.

Харин 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдсэн нь

өнгөрсөн мөн үеэс 2 оор нэмэгдсэн ба өвчний улмаас Адаацагт-1, Сайхан-Овоо-1, Сайнцагаанд-1, хүүхэд, бусад ослын улмаас Эрдэнэдалай суманд 1, Дэрэн суманд -2 хүүхэд эндсэн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр жилийн эцсийн байдлаар нас баралтын 231 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 36 тохиолдлоор буурчээ. Нас барсан хүний 16,4 хувь буюу 38 хүн эмнэлэгт нас барсан байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 28,6 хувийг эзэлж байна. Мөн осол гэмтлийн шалтгаант нас баралтын 39 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 16,9 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бүтцээр нь авч үзвэл амиа хорлосон 7, бусдад хорлогдсон 2, зам тээврийн ослоор 14, бусад ослоор 16 тохиолдол бүртгэгдсэн байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар стационарит шинээр 11141 эмчлүүлэгч хэвтэж, 11044 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 79586 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 168037 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 33,0%, амбулаторийн үзлэг 45,5%, идэвхитэй хяналт 14,2 %, гэрийн үзлэг 7,3 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 37,9 хувь нь эрэгтэй, 62,1 хувь нь эмэгтэй хүн байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар хорт хавдрын 69 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсээс 66 хүн нас барсан байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар халдварт өвчний 491 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 152 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгдийн тоо 108,6 болж өмнөх оны мөн үеэс буурсан байна.

Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл бэлгийн замын халдвар 25,3 хувь, вируст гепатит 1.6 хувь, амьсгалын замын халдвар 63,1 хувь, сүрьеэ 7.9 хувь, бусад өвчлөл 2,1 хувийг тус тус эзэлж байна.

Х.Хөдөө аж ахуй



Дундговь аймаг 2017 оны жилийн эцэст 3593.0 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 533.1 мянган толгой буюу 17.4 хувиар өссөн байна. Үүний дотор тэмээ

36.8 мянга, адуу 160.2 мянга, үхэр 75.3 мянга, хонь 1686.2 мянга, ямаа 1634.6 мянган толгой болж мал сүрэг таван төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй гарлаа.

**Дундговь аймгийн нийт малын тоо, толгойн өсөлт
бууралт/мян.толгой**




Малын өсөлтийг төрлөөр нь авч үзвэл адуу 16.9 хувь буюу 23.1 мянга, үхэр 20.1 хувь буюу 12.6 мянга, тэмээ 8.7 хувь буюу 2.9 мянга, хонь 17.3 хувь буюу 249.0 мянга, ямаа 17.7 хувь буюу 245.4 мянган толгойгоор тус тус өссөн байна.



Нийт мал сүрэгт хонь 46.9 хувь, ямаа 45.5 хувь, адуу 4.5 хувь, үхэр 2.0 хувь, тэмээ 1.0 хувийг эзэлж байна. Энэ оныг 1980 онтой харьцуулж үзэхэд нийт сүрэгт эзлэх хонины хувь 7.0 пунктээр буурч, ямааны эзлэх хувь 21.0 пунктээр өссөн, адууны эзлэх хувь 7.0 пунктээр буурсан, үхрийн эзлэх хувь 4 пунктээр буурсан, тэмээний эзлэх хувь 3 пунктээр буурсан байна.


МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ



Малын тоо 2017 оны эцэст 15 сум болон аймгийн дүнгээр 5 төрлөөр өсчээ. Нийт малын тоо Дэлгэрхангай 25.9 хувь, Сайхан-Овоо 21.1 хувь, Луус 20.4, Хулд 20.1 хувь,

Бүлэглэлт	Малтай өрхийн тоо		Нийт дүнд эзлэх хувь	
	2016	2017	2016	2017
Бүгд	7947	8283	100	100
50 хүртэл малтай	791	648	10.0	7.8
51-100	813	798	10.2	9.6
101-200	1565	1422	19.7	17.2
201-500	2635	2800	33.2	33.8
501-999	1538	1825	19.4	22
1000-1499	462	587	5.8	7.1
1500-2000	91	137	1.1	1.7
2000-с дээш	52	66	0.7	0.8

Өлзийт 19.7 хувь, Дэлгэрцогт 18.9 хувиар тус тус өссөн нь өндөр үзүүлэлт байна.




Дундговь аймгийн Эрдэнэдалай сум Монгол улсын хамгийн олон малтай сумаар шалгарлаа.

Аймгийн хамгийн олон малтай сумаар Эрдэнэдалай 550,6 мянган толгой, Сайнцагаан 382,2 мянган толгой, Адаацаг сум 286,3 мянган толгой, Өлзийт 283,4 мянган толгой, Хулд 266,3 мянган толгой мал тоолуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст 8283 малтай өрх байгаагийн 7001 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Мөн 12219 малчид байгаагаас 43,8 хувь буюу 5357 нь эмэгтэйчүүд байна. Малтай нийт өрхийн тоо өмнөх оноос 4.2 хувиар, малчин өрхийн тоо өмнөх оноос 6.2 хувиар өссөн байна.

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 790 болж, өмнөх оноос 30.6 хувиар өссөн байна. Хоёр мянгаас дээш малтай малчин өрх 66 байгаа бөгөөд Эрдэнэдалай 95, Гурвансайхан 73, Сайнцагаан 73, Дэрэн 67, Хулд 67 мянгат малчидтай болж мянгат малчдын тоогоор тэргүүлж байна.

1000-С ДЭЭШ МАЛТАЙ ӨРХИЙН ТОО



Малтай өрхийн 7.8 хувь нь 50 хүртэл, 9.6 хувь нь 51-100, 17.2 хувь нь 101-200, 33.8 хувь нь 201-500, 22.0 хувь нь 501-999, 9.5 хувь нь 1000-аас дээш малтай байна.

Малтай нэг өрхөд малын тоо 2017 онд дунджаар 435 болж өмнөх оноос 50 толгой буюу 13.0 хувиар өслөө. Малтай нэг өрхөд ногдох малын тоогоор Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Хулд, Өлзийт сумд тэргүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд оны эхний эх малын 94.0 хувь нь төллөж, гарсан төлийн 99.1 хувь нь бойжсон байна. Энэ онд оны эхний малын 0,1 хувь буюу 3362 том мал хорогдов. Үүний дотор оны эхний тэмээ, адуу, хонь, ямааны 0,1 хувь, үхрийн 0.2 хувь нь хорогджээ.

Ургац: 2017 оны 12 сарын байдлаар нийт 29.6 га-д төмс, 22.2 га-д хүнсний ногоо, 169.0 тн төмс, 77.2 тн хүнсний ногоо, өөрийн хүчээр 20 тн өвс, 9659.3 тн гар тэжээл бэлтгэсэн байна.



Х.Барилга

Аймгийн дүнгээр энэ онд 8003.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.9 хувиар буурсан байна. Энэ онд 1620.0 сая төгрөгийн орон сууцны барилга, 1462.2 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 80.2 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 459.1 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 44.9 сая төгрөгийн эрчим хүчний ажил, 820.7 зам талбайн, 164,3 сая төгрөгийн далан суваг шугамын ажил, 268.3 сая төгрөгийн бусад зам талбайн ажил, 169.0 төгрөгийн орон сууцны их засвар, 2562.1 орон сууцны бус их засварын ажил хийгдсэн байна.



XI. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2017 оны 12 сарын байдлаар 8097.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт дүнгээр 35.5 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөнд уул уурхайн олборлох аж үйлдвэр өмнөх онтой харьцуулахад 79 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Мөн боловсруулах аж үйлдвэр 1.5 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ус хангамж 24.3 хувиар өссөн байна.



ХII. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2017 оны 12-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2016 оны 12-р сартай харьцуулахад 5.0 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 5.0 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 9.6 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 6.3 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.7 хувь өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6.5 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 3.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2017 оны 12 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	XII/06	XII/13	XII/20	XII/27
1	Гурил, 1-р зэрэг, кг	1180	1180	1180	1200
2	Хонины мах, кг	4200	4200	4200	4500
3	Үхрийн мах, кг	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	3500	3500	3500	4000
5	Элсэн чихэр, кг	2066	2066	2066	2066
6	Цагаан будаа, кг	2230	2230	2230	2230
7	Шингэн сүү, л	2000	2000	2000	2000
8	Ноолуурын үнэ 1 кг	65000	65000	65000	65000
9	Бензин А-80, 1литр	1540	1540	1540	1540
10	Бензин А-92, 1литр	1720	1720	1720	1720
11	Дизель түлш 1 литр	1750	1750	1750	1750



ХIII. Гэмт хэрэг


Цагдаагийн хэлтсийн 2017 оны 12 сарын мэдээгээр аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 216 болж өнгөрсөн оны мөн үефтэй харьцуулахад 2.3 хувиар

буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үефтэй харьцуулахад 23.5 хувиар буурч, 163 хүн холбогдоод байна. 2017 оны 12 сарын байдлаар танхайрах, булаалт, ашиглал, албан тушаал, гал түймэрийн гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, хүчин, золгүй учрал, малын хулгай, дээрэм, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, бусад хэргүүд нэмэгдэж, бусдын өмчийн хулгай, залилангийн хэрэг буурч, хүн амины хэрэг мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 50.9 хувийг бусдын бие махбодьд гэмтэл учруулсан, 1.4 хувийг хүн амины хэрэг, 27.5 хувийг хулгайн, 0.9 хувийг золгүй учрал, 12 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 1.4 хувийг дээрэм, 1.4 хувийг хүчин, 1.4 хувийг залилан, 6.9 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 16.2 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 97 хүн байхад Дэлгэрцогт 209, Цагаандэлгэр 133, Сайнцагаан 97 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирол, жил бүрийн эцсийн байдлаар /сая.төг/



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 553.1 сая төгрөг, түүний 60.1 хувь буюу 332.2 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар буурч 64.1 хувьтай байна.



XIV. Байгаль орчин

Дундговь аймгийн нутгаар 2018 оны 01 сард цаг агаар ямар байх тухай урьдчилсан төлөв Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус хүйтэн байх ба олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст нутгийн хойд хэсгээр шөнөдөө 21-26 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 2-7 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч ихэнх нутгаар шөнөдөө 32-37 градус, өдөртөө 19-24 градус хүйтэн байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 27-33 градус, өдөртөө 15-20 градус хүйтэн байна. Энэ сард нутгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй. Хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

1. СУМДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2018.01.10

Сумд	нутаг дэвсгэр /мян. га-гаар /	Багийн тоо	өрхийн тоо	хүн амын тоо /суурин хүн амаар/	Шилэн кабельд холбогдсон эсэх	малын тоо / мян. тол /	УБ-аас сум хүртэлх зай км	Аймгийн төвөөс сум хүртэлх зай км	Нийт төрөлт	Нийт нас баралт
Дэлгэрцогт	250.2	3	574	1677	+	183.8	216	44	39	8
Дэрэн	362.4	4	625	2080	+	240.3	210	66	43	11
Говь-Угтаал	270.7	3	541	1591	+	187.4	240	101	32	12
Цагаандэлгэр	342.8	4	390	1047	+	128.7	198	148	15	5
Баянжаргалан	318.9	3	412	1195	+	122.6	286	148	31	4
Өндөршил	485.2	2	479	1421	+	154.7	356	182	24	7
Гурвансайхан	541.6	5	678	2149	+	259.3	300	71	43	12
Өлзийт	1542.1	6	849	2352	-	283.4	358	98	51	10
Хулд	607.0	4	731	2422	+	266.3	343	83	66	11
Луус	316.0	3	561	1827	с	173.3	310	50	38	7
Дэлгэрхангай	620.9	4	710	2279	+	184.3	357	130	51	17
Сайхан-Овоо	405.5	4	670	2180	+	189.7	392	209	38	13
Эрдэнэдалай	735.1	7	1745	5730	+	550.6	275	114	142	32
Сайнцагаан	340.6	9	4721	15508	+	382.2	260	0	339	81
Алдаацаг	330.0	5	870	2925	+	286.4	211	104	70	18
Дүн	7469.0	66	14556	46383		3593.0	-	-	1022	248

2.ХАМГИЙН ӨНДӨР, ХАМГИЙН БАГА ҮЗҮҮЛЭЛТТЭЙ СУМД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны жилийн эцсийн байдлаар				
		Аймгийн дундаж	Хамгийн их		Хамгийн бага	
Хүн амын тоо /нэг суманд ногдох/	мян.хүн	3,092.0	СЦ	15.5	Цд	1.0
			Эд	5.7	Бж	1.2
			Ад	2.9	Өш	1.4
			Эд	550.6	Цд	122.6
Малын тоо / нэг суманд ногдох/	мянган толгой	239.5	Сц	382.2	Цд	128.7
			Ад	386.4	Өш	154.7
			Хд	27.3	Цд	14.3
			Цд	25.9	Өш	16.9
1000 хүнд ногдох төрөлт	хүн	22.0	Бж	24.8	Со	17.4
			Дх	7.5	Бж	3.3
			Гу	7.5	Лс	3.8
			Со	7.0	Өт	4.3
1000 хүнд ногдох нас баралт	хүн	5.3	Гу	951.0	Цд	0.0
			Өш	495.0	Эд	95.0
			Лс	395.0	Өт	104.0
			Цд	500.0	Дц, Гу,Өш, Бж, Гс, Хд, Лс, Өт, Эд, Ад, Сц нялхсын эндэгдэлгүй	
Нялхсын нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд)	хүн	9.1	Дн	200.0		
			Со	200.0		
			Гу	245.9	Со	13.7
			Сц	219.9	Дх	18.1
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	108.6	Цд	99.5	Өт	31.8
			Дц	209.0	Өш	10.0
			Лс	135.0	Эд	11.0
			Сц	133.0	Со	14.0
18 аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг	тоо	72.0				

3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

Үзүүлэлт	мөр	2016 XII	2017 XII			17/16	
			төл	гүйц	хувь	хувь	
Нийт орлого /тусламжийн дүн/	1	39528332.6	38962854.2	39239635.7	100.7	99.3	
А. УРСГАЛ ОРЛОГО	2	6533121.8	6980336.8	7373738.0	105.6	112.9	
I. ТАТВАРЫН ОРЛОГО	3	4277974.5	4693466.5	4765271.1	101.5	111.4	
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	3350813.5	3587096.3	3660078.6	102.0	109.2	
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар		3261156.4	3487240.0	3455875.0	99.1	106.0	
Хувь хүний орлогын албан татварын буцаалт		-430194.4	-436797.3	-436797.4	0.0	0.0	
1.2 Үйл ажиллагааны орлого	5	245548.2	348701.2	422406.4	0.0	0.0	
1.3 Хөрөнгө борлуулсаны	6	112206.7	43000.0	39542.7	0.0	0.0	
1.4 Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний	7	162096.6	0.0	0.0	0.0	0.0	
1.5 Бусад татвар	8	0.0	144952.4	179051.9	0.0	0.0	
2. Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	9	101554.1	105564.0	112924.9	107.0	111.2	
3. Авто тээврийн хэрэгслийн	12	204898.1	220000.0	238535.1	0.0	116.4	
4. Бусад татвар	13	620708.8	780806.2	753732.5	96.5	121.4	
4.1 Улсын тэмдэгтийн	14	97422.3	123883.1	150244.7	121.3	154.2	
4.2 Ашигт малтмал нөөцийн	15	30597.6	21049.4	22806.5	108.3	74.5	
4.3 Газрын төлбөр	16	229317.7	240000.0	206002.4	85.8	89.8	
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	17	19569.7	29578.7	30434.3	102.9	0.0	
4.6 Усны төлбөр	18	29960.4	46000.0	28836.7	0.0	0.0	
4.7 Лиценцийн төлбөр	19	0.0	0.0	0.0	0.0	0.0	
4.6. Бусад	20	213841.1	320295.0	315407.9	0.0	147.5	
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19	2255147.3	2286870.3	2608466.9	114.1	101.6	
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	22	1877607.0	1918092.1	2189385.6	114.1	116.6	
2.2 Бусад нэр заагдаагүй	23	377540.3	368778.2	419081.3	113.6	111.0	
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	24	0.0	60000.0	86662.6	0.0	0.0	
V. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	26	32995210.8	31922517.4	31779235.1	99.6	96.3	
1. Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	28	6951974.3	6292565.8	6292565.8	0.0	90.5	
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		21928516.0	23783188.7	23639906.4	99.4	107.8	
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих		4114720.5	1846762.9	1846762.9	100.0	0.0	
Орон нутгийн төсвийн орлого / тусламжийн орлого ороогүй /	29	6533121.8	7040336.8	7460400.6	106.0	114.2	
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	30	5860889.0	2649816.0	2449700.1	92.4	41.8	
Аймгийн нийт орлого	31	12394010.8	9690152.8	9910100.7	102.3	80.0	

4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, САР БҮРИЙН ЭЦЭСТ, МЯНГАН ТӨРӨГӨӨ

Зарлагын төрөл	2016 ХП		2017 ХП		2017 ХП /2016 ХП
	Телевлегөө	Гүйцэтгэл	Телевлегөө	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	39588999.1	42328831.2	39968852.9	94.4	101.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18278314.7	18437122.2	18417961.5	99.9	100.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1993762.5	2043442.8	2036729.9	99.9	102.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3231302.7	3301027.3	3298171.6	99.7	102.1
Хангамж бараа материалын зардал	707401.4	809822.6	807638.4	99.7	114.2
Норматив зардал	1391825.4	1469509.5	1435382.8	97.7	103.1
Эд хогшил урсгал засварын зардал	284939.9	673670.3	673448.6	100.0	236.3
Томилолтын зардал	148031.7	171066.4	170379.7	99.6	115.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	902105.5	868610.4	852393.0	98.1	94.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2045680.7	3998635.9	2644263.2	66.1	129.3
Засгийн газрын дотоод шилжүүлэг	205638.4	205032.4	205032.4	100.0	99.7
Бусад урсгал шилжүүлэг	4822378.5	6553474.9	6317463.7	96.4	131.0
Хөрөнгийн зардал	5577617.7	3797416.5	3109988.1	0.0	55.8

5. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ САР БҮРИЙН ЭЦЭСТ, мянган төгрөгөөр

Сумд	2017 I-XII			2017 XII сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	107956.9	103086.1	95.5	16526.5	21448.2	129.8
Дэрэн	147931.1	161674.3	109.3	56001.3	26340.7	47.0
Говь-Угтаал	308071.6	195504.2	63.5	94610.5	40554.1	42.9
Цагаандэлгэр	978260	101554.7	103.8	28796.3	12947.1	45.0
Баянжаргалан	447952.6	430981.9	96.2	92394.6	158683.9	171.7
Өндөршил	131723.1	146387.7	111.1	37273.6	27887.2	74.8
Гурвансайхан	1607856.6	1507486.8	93.8	143587.6	54803.9	38.2
Өлзийт	288941.2	243751.1	84.4	92647.5	31204.0	33.7
Хулд	229440.2	246723.3	107.5	61618.3	32763.7	53.2
Луус	113156.8	120183.2	106.2	29777.4	23484.1	78.9
Дэлгэрхангай	198405.8	206934.7	104.3	74881.6	47187.7	63.0
Сайхан-Овоо	127159.2	149606.7	117.7	17564.5	22737.5	129.5
Эрдэнэдалай	348913.0	364402.6	104.4	93333.8	65398.9	70.1
Сайнцагаан	362725.1	414674.2	114.3	94911.8	133342.3	140.5
Адаацаг	139194.5	150834.7	108.4	35371.9	28788.0	81.4
Дундговь	3185632.7	3241786.8	101.8	276256.1	659919.7	238.9
Дүн	7842886.4	7785573.0	99.3	1245553.3	1387491.0	111.4

6.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН
МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	ХААН банк		Хас банк		Төрийн банк		Капитал банк		Бүгд		
		2016 XII	2017 XII	2016 XII	2017 XII	2016 XII	2017 XII	2016 XII	2017 XII	2016 XII	2017 XII	
1	Кассын орлого Зузаагталаар Кассын зарлага шилжүүлсэн	6,578.50	11,079.20	1921.8	1512.5	10807.5	9172.0	100.0	40.0	19407.8	21763.7	112.1
2	Зээлийн өрийн үлдэгдэл	9,179.40	10,233.30	2131.5	2614.9	1260.3	5144.6	549.5	430.9	13120.7	18423.7	140.4
3	Үүнээс: Анхаарал хандуулах зээл чанаргүй зээл	229.7	252.7	42.8	91.2	88.5	37.8	11.7	0.0	372.7	381.7	102.4
4	Иргэдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл	336.6	343.5	190.9	191.0	69.7	48.3	22.3	19.3	619.5	602.1	97.2
		20968.5	25630.2	3728.5	4281.1	7788.7	9972.6	151.6	433.3	32637.3	40317.2	123.5

7. СУУРИН ХҮН АМЫН ТОО, ӨРХ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН . сумдаар, оны эцэст

2018.01.09

сумд	Суурин хүн амын тоо			өсөлт хувь		Нийт өрхийн тоо		шилжин ирсэн хүний тоо		шилжин явсан хүний тоо	
	2015	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
он	2015	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
Дэлгэрцогт	1575	1616	1677	2.60	3.77	556	574	45	32	41	23
Дэрэн	2053	2065	2080	0.58	0.73	607	625	30	40	39	32
Говь-Угтаал	1583	1586	1591	0.19	0.32	519	541	17	37	41	34
Цагаандэлгэр	1013	1005	1047	-0.79	4.18	384	390	21	17	50	24
Баянжаргалан	1197	1168	1195	-2.42	2.31	414	412	26	28	70	37
Өндөршил	1433	1446	1421	0.91	-1.73	485	479	19	19	31	44
Гурвансайхан	2098	2088	2149	-0.48	2.92	661	678	20	33	43	17
Өлзийт	2345	2386	2352	1.75	-1.42	830	849	45	38	56	47
Хулд	2322	2379	2422	2.45	1.81	689	731	30	32	33	19
Луус	1805	1776	1827	-1.61	2.87	545	561	26	25	41	26
Дэлгэрхангай	2177	2209	2279	1.47	3.17	673	710	38	54	46	12
Сайхан-Овоо	2186	2144	2180	-1.92	1.68	642	670	29	39	75	46
Эрдэнэдалай	5690	5701	5730	0.19	0.51	1713	1745	72	63	155	64
Сайнцагаан	14602	15120	15508	3.55	2.57	4588	4721	243	262	351	165
Адаацаг	2847	2826	2925	-0.74	3.50	822	870	40	58	83	19
ДҮН	44926	45515	46383	1.31	1.91	14128	14556	701	777	1155	609

8.СУУРИН ХҮН АМЫН ТОО насны бүлгээр, хүйсээр

2018.01.04

Нас, насны бүлэг	Хүн амын тоо		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хүн ам бүгд	46383	23305	23078
0-4 настай	5259	2704	2555
5 настай	898	461	437
6 настай	818	407	411
7настай	883	485	398
8 настай	1014	527	487
9 настай	924	466	458
10-14настай	3662	1906	1756
15настай	801	391	410
16настай	759	398	361
17 настай	782	410	372
18 настай	815	417	398
19настай	805	424	381
20-24настай	4000	2048	1952
25-29 настай	3837	1973	1864
30-34настай	3632	1868	1764
35-39настай	3405	1734	1671
40-44 настай	3057	1525	1532
45-49настай	2733	1374	1359
50-54настай	2478	1227	1251
55-59настай	2060	968	1092
60-64настай	1364	593	771
65-69настай	809	354	455
70-74настай	498	228	270
75-79настай	453	188	265
80-84настай	369	143	226
85-89настай	189	60	129
90-94настай	59	21	38
95-99 настай	19	5	14
100 аас дээш настай	1	0	1

9. ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018.01.09

Сумд	өнчин хүүхдүүд			18 хүртэл насны Хүүхэдтэй гэр бүлгүй хүн /2017/		гэр бүлгүй өрх толгойлсон хүн / 2017 оноор /		Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо			Ганц бие өндөр настан өрхийн тоо		
	2015	2016	2017	эцэг	эх	эцэг	эх	2015	2016	2017	2015	2016	2017
	1. ДЦ	21	18	20	2	41	27	85	91	61	75	55	60
2. ДН	17	13	6	3	33	5	54	72	71	75	31	33	40
3. ГУ	25	16	15	1	21	7	21	74	95	103	38	37	23
4. ЦД	17	22	20	4	11	28	39	28	17	17	41	30	67
5. БЖ	1	8	11	9	56	37	62	18	19	19	30	33	34
6. ӨШ	11	17	12	0	70	14	74	47	47	45	35	36	33
7. ГС	22	13	12	1	30	7	66	91	87	72	43	44	41
8. ӨТ	18	25	18	5	45	10	61	73	68	74	47	98	54
9. ХД	12	21	20	2	29	31	78	84	82	81	42	56	46
10. ЛС	35	31	30	5	39	28	68	104	103	106	28	30	32
11. ДХ	26	25	21	13	50	35	63	91	78	122	46	46	48
12. СО	14	14	21	4	23	19	75	74	68	66	45	45	44
13. ЭД	58	62	65	16	84	58	221	248	219	231	153	162	142
14. СЦ	167	162	126	44	439	179	842	634	628	644	337	310	312
15. АД	26	22	25	6	50	30	81	108	104	100	44	49	56
ДҮН	470	469	422	115	1021	515	1890	1837	1747	1830	1015	1069	1029

10. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар 2016-2017 он

2018.01.06

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		1-5 насны хүүхдийн эндэгдэл		Гэр бүлээ бүртгүүлсэн хүний тоо		
	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	
Дэлгэрцогт	35	39	11	8	0	0	0	0	0	6	7
Дэрэн	46	43	17	11	0	1	0	3	12	9	9
Говь-Угтаал	29	32	16	12	0	0	0	0	1	4	4
Цагаандэлгэр	28	15	11	5	0	1	0	1	1	1	1
Баянжаргалан	32	31	5	4	0	0	0	0	0	9	7
Өндөршил	31	24	12	7	1	0	2	0	5	8	8
Гурвансайхан	42	43	9	12	0	0	0	0	9	14	14
Өлзийт	54	51	17	10	1	0	0	0	13	8	8
Хулд	68	66	14	11	0	0	0	0	7	12	12
Луус	39	38	11	7	0	0	0	0	10	19	19
Дэлгэрхангай	40	51	19	17	1	1	1	1	5	8	8
Сайхан-Овоо	55	38	11	13	0	1	0	2	5	10	10
Эрдэнэдалай	143	142	51	32	1	0	0	1	7	18	18
Сайнцаган	397	339	90	81	9	4	0	5	58	99	99
Адаацаг	68	70	20	18	3	0	1	1	21	31	31
Дүн	1107	1022	314	248	16	8	4	14	169	255	255
УБӨӨГ-н мэдээгээр											

11.2017 ОНЫ 4-Р УЛИРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ, СУМААР

Сум	Үйл ажиллагааны чиглэл				Ажлын байр			Шинээр бий болсон	
	Олгосон зээлийн хэмжээ	Хүнсний үйлдвэрлэл	Хөнгөн үйлдвэрлэл	Газар тариалан	Мал аж ахуй	Барилга	Бусад		Хадгалагдсан
Дэлгэрцогт	15,000,000				15,000,000	-	-	-	3
Дэрэн	15,250,000	4,250,000	3,000,000	3,000,000	5,000,000	-	-	-	5
Говь-Угтаал	8,000,000		3,000,000		5,000,000	-	-	-	2
Цагаандэлгэр	4,000,000				4,000,000	-	-	-	1
Баянжаргалан	10,000,000				10,000,000	-	-	-	3
Өндөршил	11,000,000				5,000,000	-	6,000,000	-	3
Гурвансайхан	11,000,000		3,000,000		8,000,000	-	-	-	3
Өлзийт	4,000,000				4,000,000	-	-	-	1
Хулд	28,600,000	9,600,000	2,000,000		4,000,000	-	13,000,000	-	9
Луус	19,000,000			3,000,000	4,000,000	-	12,000,000	-	5
Дэлгэрхангай	25,000,000	6,000,000	5,000,000		11,000,000	-	3,000,000	-	8
Сайхан-Овоо	11,000,000		6,000,000		5,000,000	-	-	-	3
Эрдэнэдалай	32,900,000	2,400,000	11,500,000		19,000,000	-	-	-	8
Сайнцагаан	285,250,000	81,000,000	152,250,000		35,000,000	-	17,000,000	-	70
Адаацаг	13,000,000	5,000,000	3,000,000		5,000,000	-	-	-	4
Дүн	493,000,000	108,250,000	188,750,000	6,000,000	139,000,000	-	51,000,000	-	128

12. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2018.01.04

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1071	16	43	15	401
Дэрэн	1344	17	53	21	394
Говь-Угтаал	1072	56	102	27	951
Цагаандэлгэр	671	0	0	0	0
Баянжаргалан	742	24	28	8	377
Өндөршил	989	21	49	11	495
Гурвансайхан	1417	38	31	11	219
Өлзийт	1640	18	17	11	104
Хулд	1583	40	34	19	215
Луус	1216	38	48	16	395
Дэлгэрхангай	1456	24	27	13	185
Сайхан-Овоо	1428	24	24	13	168
Эрдэнэдалай	3673	38	35	25	95
Сайнцагаан	9882	342	380	227	385
Адаацаг	1902	17	40	14	210
Дүн	30086	713	911	431	303

13. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2017 оны 12 сарын байдлаар

2018.01.04

Эдийн засгийн салбарын ангилал	Ажигд зуучилсан иргэд	Үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	119	36	23.4
Уул уурхай олборлох үйлдвэр	27	3	5.3
Боловсруулах аж үйлдвэр	6	2	1.2
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	14	7	2.8
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	1	0	0.2
Барилга	42	5	8.3
Бөөний ба жижиглэн худалдаа	15	13	2.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1	1	0.2
Зочид буудал, зоогийн газар	1	1	0.2
Мэдээлэл холбоо	1	0	0.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6	4	1.2
Ул хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1	1	0.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	0	0
Улирлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	23	15	4.5
Төрийн удирдлага ба баглан хамгаалах үйл ажиллагаа	26	12	5.1
Боловсрол	39	25	7.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	13	9	2.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	1	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	167	112	32.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	4	1	0.8
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2	1	0.4
Бүгд	509	249	100

14.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭГТЭВРИЙН САНХҮҮЖИЛТ, 2017 ОНЫ
12 сарын байдлаар

2018.01.05

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/			Тэтгэврийн санхүүжилт /мян.төг/		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	225838.0	227168.2	100.6	921274.2	921274.2	100.0
Дэрэн	236406.9	236408.9	100.0	980757.7	980757.7	100.0
Говь-Угтаал	266795.8	272356.5	102.1	759191.6	759191.6	100.0
Цагаандэлгэр	171656.7	171676.8	100.0	466252.9	466252.9	100.0
Баянжаргалан	293382.2	300256.5	102.3	482457.9	482457.9	100.0
Өндөршил	246832.7	247026.2	100.1	616319.8	616319.8	100.0
Гурвансайхан	446637.7	446715.5	100.0	880306.5	880306.5	100.0
Өлзийт	284068.0	284071.2	100.0	1033089.5	1033089.5	100.0
Хулд	332986.2	336710.1	101.1	982618.8	982618.8	100.0
Луус	263483.2	265300.6	100.7	827287.8	827287.8	100.0
Дэлгэрхангай	318216.0	322356.5	101.3	1018056.7	1018056.7	100.0
Сайхан-Овоо	240651.1	240723.1	100.0	843429.1	843429.1	100.0
Эрдэнэдалай	666415.6	671789.7	100.8	2683220.9	2683220.9	100.0
Адаацаг	327612.8	329903.9	100.7	1203186.7	1203186.7	100.0
Сайнцагаан	6350324.0	6542681.2	103.0	8577741.8	8577741.8	100.0
Дүн	10671306.9	10895144.9	102.1	22275191.9	22275191.9	100.0

15. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 12 САРЫН
байдалаар

Нийгмийн даатгалын сангийн орлого Үүнээс	2018.01.05 /сая.төг/		Хувь
	2016 оны XII сар	2017 оны XII сар	
	26213.8	10671.3	263.5
Тэтгэврийн даатгалын сангийн	21302.7	6315.7	263.5
Тэтгэмжийн даатгалын сангийн	1157.7	761.6	107.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2908.4	2893.2	102.6
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	604.4	539.3	111.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	240.6	161.5	91.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага Үүнээс	26289.2	27240.6	138.9
